



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/90

Сангиндалай

Улс, аймаг, сумын аварга малчдад
хүндэтгэл үзүүлэх зардалд нэмэлт тодотгол
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.6 дахь заалт, сумын Засаг даргын зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 04 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр шимийг нэмэгдүүлэх, мал маллагааны уламжлалт аргыг эзэмшүүлэх түүнийг боловсронгуй болгох, малын чанарыг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх, мал сүргээ малын эмчийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулан эрүүлжүүлэх ажилд бусдыг хошуучилж улс, аймаг, сумын аварга малчин шалгаруулах болзол журмыг хангасан малчдад хүндэтгэл үзүүлэх зардалд нэмэлт өөрчлөлт оруулж хавсралтаар баталсугай.

2. Хүндэтгэл үзүүлэхэд нэмж шаардагдах 3,945,000 (гурван сая есөн зуун дөчин таван мянган) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр), нягтлан бодогч (Ж.Хишигсүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

О.БАЗАРРАГЧАА

482302179